



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Нийтийн эзэмшлийн эд хөрөнгөд
хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1402B:2022 “Нийтийн эзэмшлийн талбайд байгуулах усан оргилуурт тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS1401B:2022 “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавигдах техникийн шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS1403B:2022 “Гадна мэдээллийн байгууламжид тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

1.4. UCS 1404B:2022 “Саравч, сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг дөрөвдүгээр хавсралтаар;

1.5. UCS1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандартыг тавдугаар хавсралтаар;

1.6. UCS1406B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн саванд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг зургаадугаар хавсралтаар;

1.7. UCS1407B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн сандалд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг долоодугаар хавсралтаар;

1.8. UCS1408B:2022 “Хөшөө дурсгал, хүндэтгэлийн самбарт тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг наймдугаар хавсралтаар;

1.9. UCS1409B:2022 “Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг есдүгээр хавсралтаар;

1.10. UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлаганд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг аравдугаар хавсралтаар;

1110100066

2.Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН